



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМАНД ХЭРЭГЖИХ “ЗАГИЙН УСНЫ
ХООЛОЙН ГҮНИЙ УСНЫ ОРДООС НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР ХҮРТЭЛ УС
ТАТАХ ШУГАМ ХООЛОЙ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-5435528/

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

П.ШИНЭЦЭЦЭГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ЗАХИРАЛ

Л.ДОРЖСҮРЭН

“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН
САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА

Б.БАТСАЙХАН

2023 он

ГАРЧИГ

1.	ОРШИЛ	1
2.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2.1	Төслийн зорилго, хүчин чадал.....	2
3.	ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
3.1	Уур амьсгал	3
3.2	Геоморфологи	4
3.3	Ус зүй ба гидрогеологийн нөхцөл.....	4
3.4	Хөрс.....	4
3.5	Ургамлан бүрхэвч.....	5
3.6	Нийгэм, эдийн засаг	5
3.7	Төслийн талбайн байршил	6
4.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
4.1	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц	6
5.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	8
6.	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	9
6.1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	9
6.1.1	Зам талбайг услаж тоосжилтыг дарах.....	9
6.1.2	Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх	9
6.1.3	Түр ашиглах ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагааг хангах.....	10
6.2	Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	10
6.2.1	Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах	11
6.2.2	Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх ..	11
6.2.3	Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах	12
6.2.4	Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх.....	13
6.2.5	Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр поошгинд цуглуулах	14
6.2.6	Ажилчдын кемп байгуулахын өмнө сумаас зөвшөөрөл авах, гэрээ байгуулах.....	14
6.2.7	Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих	15
6.3	Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
6.3.1	Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах.	16
6.3.2	Ус цуглуулах 14 худгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах.....	16
6.3.3	Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах.....	17
6.4	Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл	18
6.3.1	Ургамал хамгаалах талаар ажилчдад сургалт орох, танилцуулга байрлуулах.....	18
6.5	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл	19

6.5.1	Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах, Шөнө оройн цагаар ажиллахгүй байх	19
6.5.2	Амьтны мониторинг судалгаа хийх.....	20
7.	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
7.1	Газар шороо, барилгын ажлын үед эвдэрч талхлагдсан газруудад техникийн нөхөн сэргээлт хийх.....	20
7.2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөр	21
8.	ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
8.1	Дүйцүүлэн хамгаалал хийх газар нутгийг сонгох.....	22
9.	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
9.1	Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр	23
9.1.1	Орон нутгийн иргэд болон ажиллаж буй ажиллагсдад заавар зөвлөмж өгөх, мэдлэг ойлголт өгөх.....	24
9.1.2	Осол эрсдэлд зориулалтын хэрэгсэл ашиглах	24
9.2	Биологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр	24
9.3	Технологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр.....	25
9.3.1	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөний улмаас бие эрхтэнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах.....	25
10.	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
10.1	Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн, хогийн цэгийг ариутгаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.....	26
10.2	Хог хаягдал болон бохир ус тээвэрлүүлэх гэрээ байгуулах, гэрээний дагуу сумын төвийн хогийн цэг рүү ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан энгийн хог хаягдлыг зайлуулах, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж сумын хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, бохр усыг зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх, дахин боловсруулах боломжтой хог аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зайлуулах.....	27
10.3	Ажилчдын сууцнаас салхин доор 50 м-ээс багагүй зайд хог хаягдлын зориулалтын түр цэг байгуулах.....	28
10.4	Орчны эрүүл ахуйг ханган ажиллаж нийтийг хамарсан цэвэрлэгээ хийх	28
10.5	Машин механизмын эвдрэл гэмтлээс үүдэн түлш, тос масло асарч болзошгүй тул засвар үйлчилгээг тогтмол хийх, бохирдсон арчих материал, хаягдал сэлбэгийг тусгайлан бэлдсэн талбайд хураах.....	29
11.	ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	30
11.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	30
11.1.1	Агаарын чанарын хяналт шинжилгээ	30
11.1.2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ.....	31
11.1.3	Дуу чимээний хяналт	31
11.2	Усан орчны хяналт шинжилгээ	32
11.2.1	Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ.....	32
11.2.2	Усны чанарын шинжилгээ	33
11.3	Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт, шинжилгээ.....	34
11.3.1	Хөрсний агрохимийн үзүүлэлт	35
11.3.2	Хөрсний хими, физикийн шинжилгээ.....	35

11.3.3	Хөрсний хүнд металл шинжилгээ	36
11.4	Ургамлын мониторинг	36
11.5	Амьтны мониторинг судалгаа	42
12.	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	45
12.1	Байгаль орчны хөндлөнгийн аудит хийлгэх	46
12.2	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах.....	46
12.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах.....	46
13.	НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.	47
13.1	БОМТ танилцуулах хурал	47
13.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэнд мэдээлэл өгөх, уулзалт хийх 48	
14.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	49
15.	ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР	50
16.	ХАВСРАЛТ	60

1. ОРШИЛ

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд энэ тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Уг тогтоолын хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах зорилгоор гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.

Манай компани “Загийн усны хоолой”-н гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний уурхай хүртэл ус татах шугам хоолой төслийн Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг БОАЖЯ-ны 2022 оны 02-р сарын 28-ны өдрийн 13/1032 дугаар бүхий ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн БОНХЯ-ны (хуучин нэрээр) 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

БОННУ-ний ажлын хамрах хүрээ нь ус татах шугам хоолойн барилга байгууламж барих үеийн болон ашиглалтын үйл ажиллагааны үеийн байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоон үнэлсэн бөгөөд сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, улмаар хамгийн бага түвшинд хүртэл бууруулах, арилгахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж, арга зүйг Монгол улсын улсын стандарт, норм нормативд заасан шаардлагын дагуу тусгаж өгөв.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн 2021-2025 оны стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Компани ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээр байгаль орчны асуудлуудыг албан ёсоор тодорхойлж тэдгээрийг шийдвэрлэх шат дараатай алхмуудыг бодлогын баримт бичигт тусгасан. Стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, олон талын хэлэлцүүлэгт үндэслэсэн хаалтын бодлогыг бий болгох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Тус төлөвлөгөө Тавантолгой орд газрын Үйлдвэр, технологийн паркийн “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийн үйл ажиллагаанд ашиглагдах үйлдвэрлэлийн зориулалтай усыг хангах “Загийн усны хоолойн гүний усны ордоос ус татах шугам хоолой” төсөлд хамаарахын хувьд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн туслан гүйцэтгэгч компаниудад мөрдөгдөнө. Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн зорилго, хүчин чадал

Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд энэ тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

Уг тогтоолын хүрээнд Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах зорилгоор гадаргын болон гүний усыг байгаль, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр зохистой ашиглах боломжийг судлан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2021-2026 оны Бизнес төлөвлөгөөний хүрээнд өртөг зардал бууруулах, өрсөлдөх чадвар нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон зорилт дэвшүүлж байгаа бөгөөд дээрх тогтоол шийдвэрийн дагуу үндэсний их бүтээн байгуулалтын эхлэлийг бий болгож, цаашид сайн чанарын нүүрсний “Тавантолгой” брэнд бүтээгдэхүүн бий болгон олон улсын зах зээлд голлох байр суурь эзлэн аюулгүй, тогтвортой, нээлттэй, хариуцлагатай уул уурхай, үйлдвэрлэл, технологийн цогцолбор паркийг хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хүртээх, шинээр ажлын байр бий болгох, улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах гол зорилготой.

Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх болон “Эрдэнэс Тавантолгой” ХК -ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрсстэй хольж баяжуулах, чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан, орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг богино хугацаанд барьж байгуулах нөхцөлийг хангахад төслийн үндсэн зорилт оршино.

Нүүрс баяжуулах үйлдвэрийг жилд 30.0 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай байхаар хоёр үе шаттай барьж байгуулахаар төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэр нь ижил хүчин чадалтай, хоорондоо хамааралгүй ажиллах боломжтой тус бүр 10.0 сая.тонн хүчин чадалтай 3 модуль байх ба нэг модулийн үндсэн баяжуулах нь 5.0 сая.тонн хүчин чадалтай бие даасан 2 шугамтай байна.

Загийн усны хоолойн газрын доорхи усыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нзэрс баяжуулах үйлдвэр хүртэлх ус хангамжийн систем нь дараах барилга байгууламжаас бүрдэнэ:

1. Гүний худаг;
2. Ус цуглуулах шугам;
3. Ус цуглуулах усан сан;
4. Өргөлтийн насос станц;
5. Ус дамжуулах гол шугам;
6. 2х1500 м³ усан сан
7. Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцууд
8. 2х1500 м³ усан сангаас Нүүрс баяжуулах үйлдвэр хүртэлх салбар шугамууд

Тавантолгойн коксжих нүүрсний ордыг түшиглэн барихаар төлөвлөж буй нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны эх үүсвэрийг Загийн усны хоолойн (I, II дэд) хэсэгт илрүүлэн тогтоож, усны ашиглалтын нөөц баялгийг үйлдвэрлэлийн С зэргээр (63.65 л/с)-ээр тооцсон бөгөөд тус ус дамжуулах шугамаар 5,499.31 м³/хоног ус дамжуулахаар төлөвлөсөн. Тавантолгойн нүүрсний уурхайн ус хангамжийн систем нь нүүрс баяжуулах үйлдвэрийн технологийн шаардлагын улмаас 24 цаг тасралтгүй ажиллагаатай байна. Энэ байгууламж нь БНБД 40-02-16-д заасны дагуу ус хангамжийн I зэрэглэлд хамаарах учир 2 ажлын насостай байхад нөөц насос 1-ийг байрлуулах шаардлага тавигдаж байна. Иймд 1 нөөц насостой буюу нийт 3 насос суурилуулахаар техникийн ерөнхий шийдэл гаргав. Насосууд нь өөр дээрээ болон

удирдлагын самбарт тусдаа давтамж хувиргагчаар тоногловол байвал цахилгаан эрчим хүчинд хэмнэлттэй байна.

Гүний худгуудын бүлэглэлт Загийн усны хоолойн I, II дэд хэсэгт байрлах нийт 14 ширхэг гүний худаг байгуулна. Гүний худгийн барилгын эргэн тойронд “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-д заасны дагуу энгийн болон онцгой хамгаалалтын бүс тогтоон заасан зайд хамгаалалтын хашаа төлөвлөнө. Хамгаалалтын төмөр хашаа нь гүний худгийн цооногийн координатаас 50 м-ийн зайд байна.

Өргөлтийн насос станцууд, шугам хоолойн хоорондын ажиллагааны гидравлик нөхцөлийг тогтвортой, найдвартай байлгах үүднээс насос станц бүрийн сорох талд усан сан төлөвлөнө. Усан сангийн хийц, материалыг хүйтэн бүсийн онцлог, технологийн шаардлагын үүднээс шийднэ. ӨНС-1-ийн өмнө 1х500м³ эзэлхүүнтэй, ӨНС-2-ын өмнө 1х500м³ эзэлхүүнтэй 12 м диаметр дугуй хэлбэртэй, өндөр нь 5.4 м газар доорх усан сан байрлана. Ус нөөцлөх усан сан нь ус дамжуулах гол шугамын төгсгөлд системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зориулалттайгаар байгуулагдана. Ус хангамжийн системийн ус дамжуулах хоолойд осол гарсан тохиолдолд үйлдвэрлэлийн технологийн шаардлагын дагуу технологийн усыг бууруулахгүйгээр хангана.

“Загийн усны хоолой”-н гүний худгуудаас усыг салбар шугам хоолойгоор цуглуулах усан санд нэгтгэн авч өргөлтийн насос станцуудын тусламжтайгаар далд шугам хоолойгоор шахаж уурхайн ойролцоо байрлах усан санд хүргэнэ. Уг усан сангаас уурхайн ус хэрэглээ болон кемп, захиргааны барилга, унд ахуйн усны хэрэглээгээ авах юм.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн Загийн усны хоолойн ус хангамжийн төслийн тус бүр 55 кВт хүчин чадалтай 2 өргөх насос станцыг тэжээх 2 ширхэг трансформаторын 35 кВ тал дээр SEL брэндийн SEL-311L шугамын гүйдлийн дифференциал хамгаалалтыг суурилуулна. Цогтцэций сумаас Манлай сум руу явсан 35кВ-ын ЦДАШ-наас огтолгоо хийж дэд өртөө байгуулахад 12 км урттай 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татахаар төлөвлөсөн байна. Тус төслийн 35 кВ-ын ЦДАШ-д ЗТБ.35-04.18а маркийн төмөр бетон хийцтэй тулгуурыг суурилуулахаар сонгожээ.

Төслийн шугам хоолой, барилга байгууламжийн угсралтын ажлыг 6 компани түншлэл хэлбэрээр гүйцэтгэнэ. Мэдээллийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт № 1. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч компаниудын мэдээлэл

Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байгууллагын хаяг
Эс Энд ЭйТрэйд ХХК	Барилга угсралт	Улаанбаатар хот, Чингэлтэй, 1-р хороо, 8, 1 тоот
ЧММ ХХК	Барилга угсралт, засвар	Улаанбаатар хот, Хан-Уул, 3-р хороо, ажилчны, ЧММ ХХК-ийн байр
Набсан ХХК	Гадаад худалдаа, Барилга угсралт	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, ЧД, 4-р хороо дипломат 95-р байр 122-11 тоот
Тэргүүн Инвест ХХК	Гадаад худалдаа, Барилга угсралт	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Москва хороолол, 121а байр, 701 тоот
Сан ХХК	Барилга, цахилгаан, сантехник угсралтын ажил	Улаанбаатар хот, ХУД, 3-р хороо, Үйлдвэрчний гудамж-90
Бридж Констракшн ХХК	Барилга угсралт	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Бридж Плаза

3. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

3.1 Уур амьсгал

Цогтцэций сумын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Өөрөөр хэлбэл сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай, өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь -14.8⁰С хүрдэг, үнэмлэхүй

их температур нь 41.3°C хүрдэг байна. Хөрсний гадаргын дундаж температур нь ойролцоогоор 8.0°C .

Жилийн дундаж агаарын температур нь 0.9°C , хамгийн хүйтэн I сарын дундаж температур -14.6°C бол хамгийн дулаан сар болох VII сарын дундаж температур 23.1°C байдаг байна.

Цогтцэций суманд жилд дунджаар 76.7 мм хур тунадас ордог. Хур тунадасны жилийн явцыг авч үзэхэд зуны улиралд 52.7 мм буюу жилийн нийлбэр хур тунадасны 68 орчим хувь нь унадаг бол үлдсэн хувь нь зунаас бусад улирлуудад унадаг байна.

Салхины зонхлох чиглэлийн хувьд манай ерөнхий зонхилох чиглэл илэрдэг бөгөөд баруун хойноос нийт салхины чиглэлийн 38.8%, баруунаас 20.7%, баруунаас 9.4% давтагдалтай байдаг.

Салхины хурдны олон жилийн дундаж нь ойролцоогоор 5.1 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас авч үзвэл 4, 5 дугаар сард хамгийн их, харин хүйтний улиралд манай улсын нутагт төвтэй эсрэг циклон оршдог тул салхины хурд багасдаг боловч зарим жил 34 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурч байсан тохиолдол цөөнгүй.

3.2 Геоморфологи

Гадаргуугийн хувьд ерөнхийдөө нам уулс, жижиг толгод, талархаг гадаргуу зонхилох ба далайн түвшнээс дээш 1490-1590 м өргөгдсөн. Хамгийн өндөрлөг цэгүүд нь Таван толгойн талбайгаас баруун урагш орших Бага уул /1731.1 м/, зүүн хойно байх Майга улаан уул /1587.5 м/, чанх урагш орших Нэргүй өндөрлөг /1652.2 м/, зүүн урагш байх Таван толгой уул /1570 м/ зэрэг болно. Хамгийн нам цэгүүдэд Улаан нуур болон бусад нуур тойрмуудын хөндий орно. Голын хөндийнүүд нь ерөнхийдөө өргөргийн чиглэлтэй ба элсэрхэг, шаварлаг хурдсаар дүүргэгдсэн байдаг. Физик газар зүйн мужлалаар цөлийн ландшафттай говийн мужид хамаарах бөгөөд газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр цав толгод, ухаа гүвээт талын хэв шинжид багтана.

Гадаргуу нь гарал үүслийн шинж чанараа денудацийн буюу зөөгдлийн, структур-денудацийн, эрози-денудацийн буюу элэгдэл-зөөгдлийн, денудаци-хуримтлалын бүрдэлд хуваагддаг.

3.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Талбайн хэмжээнд байнгын урсгал ус байхгүй. Бороо их орсон үед хуурай сайр жалга нь түр зуурын урсгал устай болох ба уулс хоорондын хөндий, хотгоруудад түр зуурын давсархаг нуурууд үүсдэг. Уурхайн үерийн шуудуу, хөрсний овоолго, дэвсэлт хийж байгуулсан зам зэрэг антропоген байгууламжуудад хаагдан түр зуурын тогтонги ус үүсч бий болдог ба тус усыг уурхайн тоосыг бууруулахад өргөн хэрэглэж байна. Колдышева. Р.Я. нарын зохиосон гидрогеологийн 1:500 000 зурагт Улаан нуур хэмээх тойрмыг “шорвог устай нуур” гэж тэмдэглэсэн байдаг. Уг тойромд сүүлийн олон жилийн туршид ус хуримтлагдаагүй байсаар 2018 оны зуны дараалласан их аадар борооны үр дүнд эргээсээ хальж дүүрсэн байна. Уурхайчид Улаан нуурын ус хальж каррьер руу орж ирэх вий гэсэн айдас тухайн үед байсан. Гэсэн ч энэхүү их хэмжээний ус 2019 оны зуны халуунаар ууршиж алга болсон.

Таван толгойн ордын орчимд байнгын урсгал болоод тогтмол ус байхгүй учраас гадаргын ус хуурай сайрууд болон Улаан нуурт түр хугацаанд үүсч байсан, эс үүсч байсан, хуурай сайруудаар үерийн ус урсаж юмуу, ус тогтож байсан эсэх, хэрэв ус урсаж юмуу тогтож байсан бол хэдий хэмжээний урсац, тогтмол ус үүсч байсан талаар албан ёсны ямар нэгэн мэдээ сэлт байхгүй байна (2009).

Тавантолгой Цанхийн баруун болон Цанхийн зүүн уурхай тэлж Бортээгийн талбайд хөрсний овоолго байгуулж эхэлсэн цагаас Улаан нуур руу зүүн талаас цутгадаг урсгал хаагдах болсон байна. Ингэснээр 2018 оны зун улаан нуурын зүүн талд Улаан нуурын Бортээгийн отвал руу хүрдэг замын баруун талаар хангай газрын жижиг гол руугаа адил морфологитой урсгал ус үүсч улирлын турш байсан.

3.4 Хөрс

Хөрс газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт (Манлайн хөрсний

тойрогт) багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд урд хэсгээр Цөлийн бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Лицензийн талбайн хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нилээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

3.5 Ургамлан бүрхэвч

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт хамаарах бөгөөд цав толгод уулс зонхилсон, харьцангуй өндөр (д.т.д 1400-1600м) нутаг юм. Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Иран Тураны Их мужийн Төв Азийн хээр цөлийн дэд мужийн Монголын хээр цөлийн хошууны Умард говийн цөлөрхөг хээрийн дэд хошууны Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна.

3.6 Нийгэм, эдийн засаг

Өмнөговь аймаг нь 2019 оны байдлаар нийт 113,349 хүн бүртгэгдсэнээс Цогтцэций суманд 8119 хүн бүртгэгдсэн байна. Уурхайн талбайтай хамгийн ойр орших суурин газар нь Цогтцэций сум юм. Тус сум нь Монгол улсын өмнөд хилээс 240 км, аймгийн төвөөс 100 км, нийслэл Улаанбаатар хотоос 540 км-т алслагдсан бөгөөд өмнө талаараа Баян-Овоо, баруун талаараа Ханхонгор, хойд талаараа Цогт-Овоо, Дундговь аймгийн Өлзийт сумтай, зүүн талаараа Манлай сумтай тус тус хил залгана.

Хүснэгт № 2. 2021 оны хүн амын тоо

Үзүүлэлт	Өмнөговь аймаг	Цогтцэций сум
Хүн амын тоо	72943	8599
Эрэгтэй	36881	4390
Эмэгтэй	36062	4209
Өрхийн тоо	23164	2643

Өмнөговь аймаг нь 2021 оны байдлаар 2513.8 мян тоо толгой мал тоологдсоноос Цогтцэций суманд 151.65 мян толгой мал тоологдсон байна.

Хүснэгт № 3. 2021 оны мал тоо


Аймаг, сум	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өмнөговь	2513.81	102.02	31.28	160.58	626.71	1593.2
Цогтцэций	151.65	10.57	2.18	3.52	53.73	81.66

Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн 15 сум дотроо хамгийн бага буюу 700 гаруй га газар нутагтай. Түүний 16% нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй. Үүнээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХК нь Тавантолгойн бүлэг ордод идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төсөл жилдээ 20 сая.тн нүүрс олборлон экспортлож байна. Мөн хөрс хуулалт, тээврийн үйл ажиллагаанд 20-30 туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд оролцон үйл ажиллагааны эрчимд нөлөөлж байдаг.

Мөн 2019 оноос Улаанбаатар хотыг утаагүй болгох ажлын хүрээнд 100 орчим хүнд даацын машинууд нүүрс тээвэрлэж, зам дагуу нутагладаг малчдын бэлчээрийг талхалж, тоосжилт үүсгэн, өдөр шөнөгүй тээвэр хийж байна. Мөн замын дагуух худаг усыг бохирдуулах, хог хаягдал үүсгэх, зогссон газраа засвар үйлчилгээ хийж тос тосолгооны материалын асгаралтыг үүсгэж нь байгаль орчинд маш их нөлөө үзүүлж байна.

3.7 Төслийн талбайн байршил

“Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн НБҮ хүртэл ус татах шугам хоолой” төсөл нь Улаанбаатар хотоос өмнө зүгт 425 км, аймгийн төв Даланзадгадаас зүүн зүгт 90 км, Цогтцэций сумын төвөөс зүүн хойш зүгт 65 км хүртэл зайд эхлэлийн цэг орших ба эхлэлийн цэгээс шулуунаар үргэлжлэн сумын төвөөс зүүн ба зүүн урагш 6 км зайд байрлах нүүрс баяжуулах үйлдвэрийн талбайд хүрнэ.



Зураг № 1. “Загийн усны хоолой” төслийн байршлийн зураг

4. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирлагын тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргав.

4.1 Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон

Хүснэгт № 4. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				
	ялимгүй	бага	дунд	их	гамшиг
I бараг болохгүй	L	L	M	H	H
II магад болохгүй	L	L	M	H	E
III болзошгүй	L	M	H	E	E
IV магад болох	M	H	H	E	E
V лавтай болох	H	H	E	E	E

Хүснэгт № 5. Магадлалын үнэлгээний шалгуур

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болохгүй байж магад	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болзошгүй	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Магад болох	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Лавтай болох	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт № 6. Үр дагаварын үнэлгээний шалгуур

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршигийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Ялимгүй	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, Тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Гамшиг	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана

Хүснэгт № 7. Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Үйл ажиллагаа	Асуудал	Нөлөөлөл	Магадлан	ҮД ¹	ЭЗ ²	Хариу арга хэмжээ
Кемп, барилгын ажил	Хог хаягдал үүсэх	Хөрсний бохирдол	4	1	II	Хог хаягдлын ангилан ялгалт
			3	1	I	Хогийн түр цэг байгуулах, ариутгал халдваргүйжүүлэлт
			3	2	II	Гэрээ байгуулах, хатуу хог хаягдлыг зөвшөөрөлтэй цэгт зайлуулах
			3	2	II	Бохир усыг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх
Машин техникний хөдөлгөөн	Бэлчээрийн доройтол, салаа зам	Хөрсний эвдрэл	4	3	III	Зам талбайг усаар чийглэх
			4	3	III	Хөдөлгөөний хурдын хязгаарлалт, маршрутын замаар зорчуулах
			4	3	III	

¹ Үр дагавар: 1

² Эрсдэлийн зэрэглэл: I – Бага, II – Дунд, III – Өндөр, IV – Маш өндөр

	Дуу чимээний түвшин нэмэгдэх	Амьдрах орчин	4	3	III	Нөлөөллийн бүсийн айл өрхүүдийн амьжиргааг дэмжих, ажлын байраар хангах, техникийн дэмжлэг үзүүлэх
Ус хангамж /ахуй/			4	2	II	Усны хэрэглээний хяналт
Ус хангамж /барилга/	Ус ашиглах	Усны эх үүсвэр багасна	4	3	III	Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр гэх мэт
Барилга байгууламж, шугам хоолой	Зөвшөөрөлгүй ашиглах	ТТАМ нөөц, хууль зөрчих	4	4	V	Зөвшөөрөлтэй ААН-тэй гэрээ байгуулж ашиглах
	Нүх, ухаш үүсэх	Мал амьтан унах	3	2	III	ХАБ-н арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх
Ажилчдын кемп	Зөвшөөрөлгүй ашиглах	Хөрс, газрын гадарга доройтох	4	3	IV	Орон нутгаас түр ашиглах зөвшөөрөл авах, гэрээ байгуулах

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянаж байх явдал юм.

“Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн НБУ хүртэл ус татах шугам хоолой” төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцооны элементүүдийг хэрэгжүүлэх;
- Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх;
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргагүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах;
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах;
- “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлого, дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах;
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх;
- БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох;
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.1.1	Зам талбайг усалж тоосжилтыг дарах	Шороон зам, барилгын ажлын талбай	Ажил гүйцэтгэх шугамын трасс дагуу батлагдсан маршрутын дагуу зорчиж зам талбайн усалгааг хийж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажилласан.	100%
6.1.2	Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх	Төслийн талбайд жилд 2 удаа	Ус хангамжийн шугамын төслийн барилга угсралтын ажлын үед машин механизм ажиллаж байгаа байгаа газруудад дуу шуугианы хэмжилтийг хийж ажилласан. Стандарт шаардлага хангаагүй машин техникт засвар үйлчилгээ хийж ажилласан.	100%
6.1.3	Бохирын цооногт FM болон септоник бодис хийж бактерийг устган, ялзруулж, саарал ус болсоны дараа зөөвөрлөж асгаж байх	Төслийн талбай, түүний эргэн тойрон	Төслийн гүйцэтгэгч компаниудын түр кемпүүдэд 2ш боловсон ариун цэврийн байгууламж байрлуулан ашигласан.	100%

6.1.1 Зам талбайг усалж тоосжилтыг дарах

Ажил гүйцэтгэх шугамын трасс дагуу батлагдсан маршрутын дагуу зорчиж зам талбайн усалгааг хийж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажилласан.



Зураг № 2. Зам талбайн усалгааг хийж маршрутын зам дагуу зорчих тэмдэглэгээ байрлуулсан байдал

6.1.2 Төсөлд хэрэглэх машин техникүүдэд хэмжилт хийлгэж, шуугианы хэмжээ MNS 4599:2003 стандартын шаардлага хангаагүй машиныг засварлах, шинэчлэх

Ус хангамжийн шугамын төслийн барилга угсралтын ажлын үед машин механизм ажиллаж байгаа байгаа газруудад дуу шуугианы хэмжилтийг хийж ажилласан. Стандарт шаардлага хангаагүй машин техникт засвар үйлчилгээ хийж ажилласан.



Зураг № 3. Шаардлага хангаагүй машин техникийг засварт зогсоосон

6.1.3 Түр ашиглах ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагааг хангах

Төслийн гүйцэтгэгч компаниудын түр кемпүүдэд 2ш боловсон ариун цэврийн байгууламж байрлуулан ашигласан.



Зураг № 4. Ажилчдын хотхонд ариун цэврийн байгууламж байрлуулсан байдал

6.2 Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.2.1	Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах /хлорын шохой - Эколос/	Кемпүүдийн нүхэн жорлонд	Ажилчдын түр кемпийн нүхэн жорлонгуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж ажилласан.	100%
6.2.2	Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх	Кемп орчим	Төслийн гүйцэтгэгч 3 түншлэлийн ажилчдын түр кемпийн гадна нийт 400м явган зам цутгаж 220м ³ хайрга дэвсэж тохижуулсан.	100%
6.2.3	Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах	Туслан гүйцэтгэгч компаниуд	Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж байгаа бетон зуурмагийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан гэрээний дагуу төслийн үндсэн болон туслах барилга байгууламжийн бетон цутгалтын ажлыг гүйцэтгэсэн.	100%
6.2.4	Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх.	Төслийн талбай	Ус хангамжийн шугам хоолойн шуудууны ухлагын ажил гүйцэтгэхэд гарсан 7200м ³ үржил шимтэй өнгөн хөрсийг ухлагын баруун гар талд тусд нь хадгалж технологийн дагуу буцаан булах ажлыг гүйцэтгэж ажилласан.	100%

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.2.5	Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр поошгинд цуглуулах	Машины зогсоол	Хөрсийг химийн бодисоор бохирдуулахаас сэргийлж шатах тослох материалыг тусгайлан бэлтгэсэн талбайд төмөр поошгинд цуглуулсан.	100%
6.2.6	Ажилчдын кемп байгуулахын өмнө сумаас зөвшөөрөл авах, ЭТТ ХК-аас хяналт тавьж ажиллах	Туслан гүйцэтгэгч компаниуд	Төслийн гүйцэтгэгч 3 түншлэл ажилчдын түр кемп байгуулах газрын байршил тогтоох тухай Цогтцэций сумын Засаг даргын захирамж гарсан. Тус захирамжийн дагуу ажилчдын кемпийг байгуулан тохижуулж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	100%
6.2.7	Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих	Сум-төслийн талбай хоорондын шороон зам	Барилга угсралтын ажилд оролцож байгаа компанийн ажилтнууд, техник тоног төхөөрөмж, ачаа бараа зөөвөрлөх машинууд явах трассын Салбарын захирлаар батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн болон маршрутын бус замаар зорчоогүй тээврийн хэрэгслийг малчид иргэдэд таниулах зорилгоор гүйцэтгэгч 3 түншлэл нь А, В, С гэсэн тус тусын тэмдэглэгээг өөрсдийн авто машин болон механизмууд дээрээ байрлуулсан.	100%

6.2.1 Ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис цацах

Ажилчдын түр кемпийн нүхэн жорлонгуудад ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж ажилласан.



Зураг № 5. Нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан

6.2.2 Хөрсний элэгдэл эвдрэлээс сэргийлж явган хүний зам бий болгох, тохижилт хийх

Төслийн гүйцэтгэгч 3 түншлэлийн ажилчдын түр кемпийн гадна нийт 400м явган зам цутгаж 220м³ хайрга дэвсэж тохижуулсан.



Зураг № 6. "ЧММ" болон "Набсан" ХХК-ны түр кэмпийн зураг



Зураг № 7. "Сан" болон "Эс энд Эй Трейд" ХХК-ны түр кэмпийн зураг



Зураг № 8. Түр кэмпийн гадна зам талбайн зураг

6.2.3 Эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлтэй ААНБ-тай гэрээ байгуулж хайрга, дайрга, бетон зуурмаг ашиглах

Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж байгаа бетон зуурмагийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан гэрээний дагуу төслийн үндсэн болон туслах барилга байгууламжийн бетон цутгалтын ажлыг гүйцэтгэсэн. Гэрээт байгууллагууд дараах аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж гэрээний шндсэн дээр хайрга, дайрга, бетон зуурмаг ашигласан байна. Үүнд:

1. Набсан ХХК – Зул соёмбо ХХК гэрээтэй.
2. Эс Энд Эй Трейд ХХК – Эс Ти Эй ХХК гэрээтэй.
3. ЧММ ХХК – Зул соёмбо ХХК гэрээтэй



Зураг № 9. Бетон зуурмагийг үйлдвэрээс зуурмагийн машинаар тээвэрлэн авч буй байдал



Зураг № 10. Бетон зуурмагийг үйлдвэрээс зуурмагийн машинаар тээвэрлэн авч буй байдал

6.2.4 Хуулсан өнгөн хөрсийг стандартын дагуу хадгалах, булах үйл ажиллагааг стандартын дагуу хийх.

Ус хангамжийн шугам хоолойн шуудууны ухлагын ажил гүйцэтгэхэд гарсан 72000м³ үржил шимтэй өнгөн хөрсийг ухлагын баруун гар талд тусд нь хадгалж технологийн дагуу буцаан булах ажлыг гүйцэтгэж ажилласан.



Зураг № 11. Өнгөн хөрсийг ухлагын баруун талд тусад нь хадгалсан байдал



Зураг № 12. Шугам хоолойг угсарч шуудууг технологийн дагуу буцаан булж буй байдал

6.2.5 Хөрсийг химийн бодисоор бохирдуулах шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх, төмөр пошгинд цуглуулах

Хөрсийг химийн бодисоор бохирдуулахаас сэргийлж шатах тослох материалыг тусгайлан бэлтгэсэн талбайд төмөр пошгинд цуглуулсан.




Зураг № 13. Ашиглалтаас гарсан аккумулятор, батерейг тусгай талбайд цуглуулсан



Зураг № 14. Тос, тослогооны материалыг тусгай талбайд төмөр пошгинд цуглуулсан байдал

6.2.6 Ажилчдын кемп байгуулахын өмнө сумаас зөвшөөрөл авах, гэрээ байгуулах

Төслийн гүйцэтгэгч 3 түншлэл ажилчдын түр кемп байгуулах газрын байршил тогтоох тухай Цогтцэций сумын Засаг даргын захирамж гарсан. Тус захирамжийн дагуу ажилчдын кемпийг байгуулан тохижуулж захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.



Зураг № 15. Түр көмп байгуулах Засаг даргын захирамж

6.2.7 Замын маршрут батлах, маршрутын дагуу зорчих, хяналт тавих

Барилга угсралтын ажилд оролцож байгаа компанийн ажилтнууд, техник тоног төхөөрөмж, ачаа бараа зөөвөрлөх машинууд явах трассын Салбарын захирлаар батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн болон маршрутын бус замаар зорчоогүй тээврийн хэрэгслийг малчид иргэдэд таниулах зорилгоор гүйцэтгэгч 3 түншлэл нь А, В, С гэсэн тус тусын тэмдэглэгээг өөрсдийн авто машин болон механизмууд дээрээ байрлуулсан.



Зураг № 16. Батлагдсан маршрут, замын трассын дагуух тэмдэглэгээ

6.3 Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.3.1	Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах.	Зөрчил гаргахгүй ажиллах	Гадаргын болон газрын доорх усны нөөцийг хатуу хаягдлаар бохирдохоос сэргийлж хог хаягдлыг түр хогийн цэгт цуглуулж Цогтцэций сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэн ажилласан. Ажилчдын түр кемпийн ариун цэврийн байгууламжийн бохир усыг сумын цэвэрлэх байгууламжид нийлүүлж, нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж зөрчилгүй ажилласан.	100%
6.3.2	Ус цуглуулах 14 худгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	14 худаг	Загийн усны хоолойн газрын доорх усны ордод 2015-2016 онуудад хийгдсэн гидрогеологийн нарийвчилсан хайгуул судалгааны ажлын үр дүнд үндэслэн Монгол ус ТӨААТҮГ-аас 2017 онд ус ашиглах дүгнэлт гарсан. Тус дүгнэлтийн дагуу Эрдэнэс Тавантолгой ХК Нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах зорилгоор мэргэжлийн байгууллагуудаар ТЭЗҮ, зураг төслийг боловсруулан. 2022 онд ус хангамжийн төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 оны 8 дугаар сард Усны газраас цооног ерөмдөх зөвшөөрөл авч ашиглалтын 14 худгийн цооногийн ерөмдлөгийг мэргэжлийн байгууллага гүйцэтгэж шавхалтын ажлыг төсөлд зааснаар гүйцэтгэсэн. Одоогоор Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус авч ашиглаагүй, ашиглалтын цооногуудад насос суурилуулаагүй байна.	100%
6.3.3	Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах	2 малчны худаг	Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн үйл ажиллагаанаас нөлөөллийн бүсийн малчны худгуудад үзүүлэх сөрөг нөлөөг хянах зорилгоор малчны худгуудаар явж бага гүний уст худгуудын усны түвшин хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн үед худаг ашиглагч малчдыг байлцуулж хэмжилтийг хамтран гүйцэтгэж ажилласан.	100%

6.3.1 Хатуу, шингэн хаягдлаар гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах.

Гадаргын болон газрын доорх усны нөөцийг хатуу хаягдлаар бохирдохоос сэргийлж хог хаягдлыг түр хогийн цэгт цуглуулж Цогтцэций сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэн ажилласан. Ажилчдын түр кемпийн ариун цэврийн байгууламжийн бохир усыг сумын цэвэрлэх байгууламжид нийлүүлж, нүхэн жорлонд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж зөрчилгүй ажилласан.

6.3.2 Ус цуглуулах 14 худгийн усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах

Загийн усны хоолойн газрын доорх усны ордод 2015-2016 онуудад хийгдсэн гидрогеологийн нарийвчилсан хайгуул судалгааны ажлын үр дүнд үндэслэн Монгол ус

ТӨААТҮГ-аас 2017 онд ус ашиглах дүгнэлт гарсан. Тус дүгнэлтийн дагуу Эрдэнэс Тавантолгой ХК Нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах зорилгоор мэргэжлийн байгууллагуудаар ТЭЗҮ, зураг төслийг боловсруулан. 2022 онд ус хангамжийн төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 оны 8 дугаар сард Усны газраас цооног өрөмдөх зөвшөөрөл авч ашиглалтын 14 худгийн цооногийн өрөмдлөгийг мэргэжлийн байгууллага гүйцэтгэж шавхалтын ажлыг төсөлд зааснаар гүйцэтгэсэн. Одоогоор Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус авч ашиглаагүй, ашиглалтын цооногуудад насос суурилуулаагүй байна.



Зураг № 17. 2022 онд ашиглалтын цооног өрөмдөж шавхалт хийсэн



Зураг № 18. Гүний худгийн дотор холболт хийсэн, ашиглалтын цооногийн одоогийн байдал

6.3.3 Төслийн талбай дахь нутгийн иргэдийн ашиглалтын худаг дунд усны түвшин тогтоох автомат түвшин хэмжигч суурилуулах

Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн үйл ажиллагаанаас нөлөөллийн бүсийн малчны худгуудад үзүүлэх сөрөг нөлөөг хянах зорилгоор малчны худгуудаар явж бага гүний уст худгуудын усны түвшин хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн үед худаг ашиглагч малчдыг байлцуулж хэмжилтийг хамтран гүйцэтгэж ажилласан.



Зураг № 19. Малчны худгуудад гар түвшин хэмжигчээр хэмжилт хийж ажилласан



Зураг № 20. Малчны худагуудад гар түвшин хэмжигчээр хэмжилт хийж буй байдал

6.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.4.1	Ургамал хамгаалах талаар ажилчдад сургалт орох, танилцуулга байрлуулах	2-оос доошгүй удаа	Төслийн гүйцэтгэгч компаниудын ИТА, ХАБ, БО хариуцсан ажилтнуудад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн БОУБ-ын хэлтсээс ургамал хамгааллын чиглэлээр 1 удаа сургалт орсон. Сургалтанд хамрагдсан гүйцэтгэгч компанийн ИТА, БО-ны ажилтнууд ажилчиддаа энэ тухай сургалтыг зохион байгуулсан.	100%

6.3.1 Ургамал хамгаалах талаар ажилчдад сургалт орох, танилцуулга байрлуулах

Төслийн гүйцэтгэгч компаниудын ИТА, ХАБ, БО хариуцсан ажилтнуудад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн БОУБ-ын хэлтсээс ургамал хамгааллын чиглэлээр 1 удаа сургалт орсон.

Сургалтанд хамрагдсан гүйцэтгэгч компанийн ИТА, БО-ны ажилтнууд ажилчиддаа энэ тухай сургалтыг зохион байгуулсан.



Зураг № 21. Захиалагч Эрдэнэс Тавантолгой ХК-иас нийт ажилтнуудад БО-ны сургалт орж буй байдал



Зураг № 22. Гүйцэтгэгч компаниуд ажилтнууддаа ургамал хамгаалах талаар сургалт орж буй байдал

6.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
6.5.1	Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах, Шөнө оройн цагаар ажиллахгүй байх	Төслийн турш	Төслийн талбайн ойролцоо байрлах худгийг арчлан хамгаалах арга хэмжээ авч ажилласан. Барилга угсралтын ажил үргэлжлэх хугацаанд шөнө, оройн цагаар хүнд машин механизм ажиллахгүй байхаар зохион байгуулалт хийж хяналт тавьж ажилласан.	100%
6.5.2	Амьтны мониторинг судалгаа хийх	Жилд 2 удаа	“Загийн усны хоолой” төслийн талбайд 2023 оны 10-р сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-н мэргэжилтнүүдтэй хамтран амьтны мониторинг ажлыг гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд төслийн талбайн үйл ажиллагаа явуулж буй хэсэг болон нөлөөллийн бүс орчмын зонхилох том хөхтөн, махчтан, шувууны зүйлийн бүрдэлийн тодорхойлох зорилгоор тухайн ажлыг гүйцэтгэсэн болно.	100%

6.5.1 Төслийн талбайн ойр орчмын амьтад ундаалдаг усны эх үүсвэрийг тогтоон, арчлан хамгаалах арга хэмжээ авах, Шөнө оройн цагаар ажиллахгүй байх


Төслийн талбайн ойролцоо байрлах худгийг арчлан хамгаалах арга хэмжээ авч ажилласан. Барилга угсралтын ажил үргэлжлэх хугацаанд шөнө, оройн цагаар хүнд машин механизм ажиллахгүй байхаар зохион байгуулалт хийж хяналт тавьж ажилласан.



Зураг № 23. Төслийн талбайд орших малчны худгийг амлаж буй байдал

6.5.2 Амьтны мониторинг судалгаа хийх

“Загийн усны хоолой” төслийн талбайд 2023 оны 10-р сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-н мэргэжилтнүүдтэй хамтран амьтны мониторинг ажлыг гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд төслийн талбайн үйл ажиллагаа явуулж буй хэсэг болон нөлөөллийн бүс орчмын зонхилох том хөхтөн, махчтан, шувууны зүйлийн бүрдэлийн тодорхойлох зорилгоор тухайн ажлыг гүйцэтгэсэн болно.



Зураг № 24. Судалгааны талбайн байршлын зураг

Хээрийн хайгуул судалгааны талбайг сонгохдоо үйл ажиллагаа явуулж буй төслийн орчны бүс болон нөлөөллийн бүсийг хамруулан судалгааны ажлыг гүйцэтгэсэн. судалгаа хийгдэх талбайн гадаргын онцлог, хэмжээ, амьтны тархац зэргийг харгалзан үзэж 6 цэгт шулуун замналын аргаар 72 км талбайд судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
7.1	Газар шороо, барилгын ажлын үед эвдэрч талхлагдсан газруудад техникийн нөхөн сэргээлт хийх	Шугам хоолойн трасс дагуу болон насос станц	Шугам хоолойн угсралтын ажил бүрэн дуусч ухлагаас гарсан материалыг технологийн дагуу буцаан булж нөхөн сэргээлтийг 100% хийж гүйцэтгэсэн. Шугамын трассын дагуух их цэвэрлэгээг жилд 2 удаа хийж ажилласан.	100%
7.2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөр	1000 ширхэг	Төслийн үйл ажиллагааны хүрээнд цаашид арчилж ургуулах боломжийг судлан өргөлтийн насос станц №1, №2-ийн хашаанд тус бүр 500 ширхэг модыг намрын мод тарилтаар тарьсан.	100%

7.1 Газар шороо, барилгын ажлын үед эвдэрч талхлагдсан газруудад техникийн нөхөн сэргээлт хийх

Шугам хоолойн угсралтын ажил бүрэн дуусч ухлагаас гарсан материалыг технологийн дагуу буцаан булж нөхөн сэргээлтийг 100% хийж гүйцэтгэсэн. Шугамын трассын дагуух их цэвэрлэгээг жилд 2 удаа хийж ажилласан.



Зураг № 25. Ухлагаас гарсан хөрсөөр буцаан булсан байдал



Зураг № 26. Ухлагаас гарсан хөрсөөр буцаан булсан байдал

7.2 Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон “Тонн баялаг-Нэг мод” хөтөлбөр

Төслийн үйл ажиллагааны хүрээнд цаашид арчилж ургуулах боломжийг судлан өргөлтийн насос станц №1, №2-ийн хашаанд тус бүр 500 ширхэг модыг намрын мод тарилтаар тарьсан.



Зураг № 27. Өргөлтийн насос станцад сухай мод тарьж буй байдал

8. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
8.1	Дүйцүүлэн хамгаалал хийх газар нутгийг сонгох	2818 га	Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ны үндсэн үйл ажиллагаа болох уурхайн дүйцүүлэн хамгаалах ажил нь Цогтцэций сумын нутагт орших Шангай, Дугантын хэц орчмын 99000 га талбайд хэрэгжүүлж байгаа бөгөөд төсөл захиалагчийн зүгээс дээрх байршилд залгуулан хийх хүсэлтэй байгаа тул уг байршилд хийж болох эсэх талаар тодруулахаар албан бичгээр сумын ЗДТГ-т хандсан байна.	50%
8.2	Сонгогдсон газарт суурь судалгаа хийх	2818 га	“Биологийн олон янзын байдлын дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх” зөвлөх үйлчилгээний тендерийг компанид тогтоосон онц байдал болон улсын санхүүгийн нөхцлийг сайжруулахтай холбоотойгоор 2023 оны 09 сарын 28-нд зарлаж, хураангуй жагсаалт үүсэж тухайн байгуулагуудаас үнийн санал ирүүлэх ажил хийгдэж байна. 2023 оны 11-р сарын 01-ны өдөр тендерийг хааж санхүүгийн санал үнэлэх ажил хийгдэнэ. Одоогийн байдлаар хураангуй жагсаалтанд 3 байгууллага шалгарсан байна. Үүнд: “Эхмонголын байгаль”, ХХК, “Монгол улсын Их Сургууль”, “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо”	0%


8.1 Дүйцүүлэн хамгаалал хийх газар нутгийг сонгох

Загийн усны хоолойн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дүйцүүлэн хамгаалал явуулах тохиромжтой байрлал нь Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт орших Говийн бага дархан газрын өргөтгөл /төслийн талбайгаас зүүн зүгт 80-120 км/, Загийн усны өргөтгөл /төслийн талбайгаас зүүн хойд зүгт 110-160 км/, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумын нутагт орших Тулгын тал /төслийн талбайгаас зүүн зүгт 40-70 км/ тус тус тодорхойлогдсон байна. Энд дурдсан дүйцүүлэн хамгаалах газар боломжит газар нутгууд нь төслийн талбай орчимд нүүрлэх биологийн олон янз байдлын алдагдлыг тэтгэх боломжтой гэж үзсэн байна.

Гэвч төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Тавантолгой” ХК-ны үндсэн үйл ажиллагаа болох уурхайн дүйцүүлэн хамгаалах ажил нь Цогтцэций сумын нутагт орших Шангай, Дугантын хэц орчмын 99000 га талбайд хэрэгжүүлж байгаа бөгөөд төсөл захиалагчийн зүгээс дээрх байршилд залгуулан хийх хүсэлтэй байгаа тул уг байршилд хийж болох эсэх талаар тодруулахаар албан бичгээр сумын ЗДТГ-т хандсан байна.

8.2 Сонгогдсон газарт суурь судалгаа хийх

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх газар нутагт 2019 онд Эс И Си ХХК-иар “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө”-ний суурь судалгааг хийлгэсэн. Мөн судлагаанд үндэслэн “Биологийн олон янзын байдлын дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх” зөвлөх үйлчилгээний тендерийг компанид тогтоосон онц байдал болон улсын санхүүгийн нөхцлийг сайжруулахтай холбоотойгоор 2023 оны 09 сарын 28-нд зарлаж, хураангуй жагсаалт үүсэж тухайн байгуулагуудаас үнийн санал ирүүлэх ажил хийгдэж байна. 2023 оны 11-р сарын 01-ны өдөр тендерийг хааж санхүүгийн санал үнэлэх ажил хийгдэнэ. Одоогийн байдлаар хураангуй жагсаалтанд 3 байгууллага шалгарсан байна. Үүнд: “Эхмонголын байгаль” ХХК, “Монгол улсын Их Сургууль”, “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо”



Зураг № 28. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын гүйцэтгэгч сонгох зөвлөх үйлчилгээний тендер зарласан байдал

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

9.1 Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.1.1	Орон нутгийн иргэд болон ажиллаж буй ажиллагсдад заавар зөвлөмж өгөх, мэдлэг ойлголт өгөх	Жилд 2 удаа	Төслийн хэмжээнд ажиллаж буй нийт ажилтнуудад гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг Цогтцэций сумын онцгой байдлын ангитай хамтран зохион байгуулсан. Мөн гүйцэтгэгч компаниудын ХАБ-ын ажилтнууд шинээр ирсэн ажилтнууддаа энэ чиглэлийн сургалтыг орж ажилласан.	100%
9.1.2	Осол эрсдэлд зориулалтын хэрэгсэл ашиглах	1 багц	Түр кемп тус бүрт галын аюулгүй ажиллагааны самбар болон багаж хэрэгслийг хангалттай хэмжээгээр байршуулсан.	100%

9.1.1 Орон нутгийн иргэд болон ажиллаж буй ажиллагсдад заавар зөвлөмж өгөх, мэдлэг ойлголт өгөх

Төслийн хэмжээнд ажиллаж буй нийт ажилтнуудад гамшгаас урьдчилан сэргийлэх сургалтыг Цогтцэций сумын онцгой байдлын ангитай хамтран зохион байгуулсан. Мөн гүйцэтгэгч компаниудын ХАБ-ын ажилтнууд шинээр ирсэн ажилтнууддаа энэ чиглэлийн сургалтыг орж ажилласан.



Зураг № 29. Нийт ажилтнуудад сумын онцгой байдлын ангитай хамтран сургалт орсон

9.1.2 Осол эрсдэлд зориулалтын хэрэгсэл ашиглах

Түр кемп тус бүрт галын аюулгүй ажиллагааны самбар болон багаж хэрэгслийг хангалттай хэмжээгээр байршуулсан



Зураг № 30. Галын аюулгүй ажиллагааны самбар, галын сарайг түр кемпүүдэд байрлуулсан байдал

9.2 Биологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.2.1	Төсөл хэрэгжих явцад тухайн бүс нутаг болон ОУ, Монгол улсыг хамарсан өвчлөл гарч байгаа эсэхэд байнга анхаарч, гарсан тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Төслийн талбай болон бүс нутаг	Төслийн хэрэгжих хугацаанд цар тахлын үеийн аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон ажилласан.	100%

Төсөл хэрэгжих хугацаанд Олон улсыг хамарсан цар тахал бүртгэгдээгүй тул аюулгүй ажиллагааг мөрдлөг болгон ажилласан.

9.3 Технологийн гаралтай ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
9.3.1	Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөний улмаас бие эрхтэнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах	Ажилчид	Гүйцэтгэгч компани бүр барилга угсралтын ажлын үйл ажиллагаандаа технологи ажиллагааны заавар боловсруулж, өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэхдээ эрсдлийн үнэлгээ хийж ажилласан.	100%

9.3.1 Үйл ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид аюулгүй ажиллагааны дүрэм зөрчсөний улмаас бие эрхтэнээ гэмтээх, эрүүл мэндээр хохирох эрсдэл учирч болзошгүй тул эрсдэлээс хамгаалах арга хэмжээг нарийвчилж боловсруулах

Гүйцэтгэгч компани бүр барилга угсралтын ажлын үйл ажиллагаандаа технологи ажиллагааны заавар боловсруулж, өндөр эрсдэлтэй ажил гүйцэтгэхдээ эрсдлийн үнэлгээ хийж ажилласан.



Зураг № 31. Техникийн үзлэгийн хуудас

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.1	Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн, хогийн цэгийг ариутгаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	7 хоног бүр	Ажилчдын түр кемп болон ахуйн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хогийн цэгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.	100%

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
10.2	Хог хаягдал болон бохир ус тээвэрлүүлэх гэрээ байгуулах, гэрээний дагуу сумын төвийн хогийн цэг рүү ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан энгийн хог хаягдлыг зайлуулах, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж сумын хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, бохир усыг зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх, дахин боловсруулах боломжтой хог аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зайлуулах	Тухай бүрт	Төслийн гүйцэтгэгч компаниуд хог хаягдлын гэрээг Тэгш дүүрэн ОНӨААТҮГ-тай, бохир ус тээвэрлэх гэрээг Арцат шанх ХХК-тай байгуулан ажилласан.	100%
10.3	Ажилчдын сууцнаас салхин доор 50 м-ээс багагүй зайд хог хаягдлын зориулалтын түр цэг байгуулах	Кемп бүр	Ажилчдын түр кемп тус бүрт хогийн цэгийг бороо цас, үерийн усанд автах ааргүй салхи шуурганд хийсэхээргүй, хог хаягдлыг ангилан ялгах зориулалттайгаар байгуулан ашигласан.	100%
10.4	Орчны эрүүл ахуйг ханган ажиллаж 14-30 хоногт 1 удаа нийтийг хамарсан цэвэрлэгээ хийх	Тухай бүр	Бүх нийтийн их цэвэрлэгээг жилд 2 удаа хийж тайланг захиалагч болон орон нутагт хүргүүлэн ажилласан	100%
10.5	Машин механизмын эвдрэл гэмтлээс үүдэн түлш, тос масло асгарч болзошгүй тул засвар үйлчилгээг тогтмол хийх, бохирдсон арчих материал, хаягдал сэлбэгийг тусгайлан бэлдсэн талбайд хураах	Засварын талбай	Засварын түр талбайг хөрсөнд нөлөөлөл үзүүлэхгүй байхаар тусгайлан бетон цутгаж тохижуулан хийсэн.	100%

10.1 Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн, хогийн цэгийг ариутгаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх

Ажилчдын түр кемп болон ахуйн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хогийн цэгийн ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.



Зураг № 32. Хог хаягдлыг Тэгш дүүрэн ОНӨААТҮГ гэрээт байгууллагаар ачуулан ажиллаж буй байдал

10.2 Хог хаягдал болон бохир ус тээвэрлүүлэх гэрээ байгуулах, гэрээний дагуу сумын төвийн хогийн цэг рүү ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан энгийн хог хаягдлыг зайлуулах, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж сумын хоёрдогч түүхий эд авдаг цэгт тушаах, бохир усыг зөвшөөрөлтэй ААН-д нийлүүлэх, дахин боловсруулах боломжтой хог аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зайлуулах

Төслийн гүйцэтгэгч компаниуд хог хаягдлын гэрээг Тэгш дүүрэн ОНӨААТҮГ-тай, бохир ус тээвэрлэх гэрээг Арцат шанх ХХК-тай байгуулан ажилласан.



Зураг № 33. Ахуйн бохир усыг Арцат шанх ХХК соруулж цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн



Зураг № 34. 2023 оны хог хаягдлын хураамж төлсөн баримт

10.3 Ажилчдын сууцнаас салхин доор 50 м-ээс багагүй зайд хог хаягдлын зориулалтын түр цэг байгуулах

Ажилчдын түр кемп тус бүрт хогийн цэгийг бороо цас, үерийн усанд автахааргүй салхи шуурганд хийсэхээргүй, хог хаягдлыг ангилан ялгах зориулалттайгаар байгуулан ашигласан.



Зураг № 35. Түр хогийн цэг байгуулсан байдал



Зураг № 36. Түр хогийн цэг байгуулсан байдал

10.4 Орчны эрүүл ахуйг ханган ажиллаж нийтийг хамарсан цэвэрлэгээ хийх

Бүх нийтийн их цэвэрлэгээг жилд 2 удаа хийж тайланг захиалагч болон орон нутагт хүргүүлэн ажилласан.




Зураг № 37. Сумаас зохион байгуулсан хог хаягдлын их цэвэрлэгээнд оролцож буй байдал



Зураг № 38. Их цэвэрлэгээгээр цуглуулсан хогийг сумын төвлөрсөн хогийн цэгт буулгаж буй байдал

10.5 Машин механизмын эвдрэл гэмтлээс үүдэн түлш, тос масло асгарч болзошгүй тул засвар үйлчилгээг тогтмол хийх, бохирдсон арчих материал, хаягдал сэлбэгийг тусгайлан бэлдсэн талбайд хураах

Засварын түр талбайг хөрсөнд нөлөөлөл үзүүлэхгүй байхаар тусгайлан бетон цутгаж тохижуулан хийсэн.



Зураг № 39. Хаягдал тос цуглуулах байгууламж байгуулсан байдал



Зураг № 40. Түр засварын талбайг бетон суурьтай болгосон байдал

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

11.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.1.1	Аэрозол: PM2.5, PM10, нийт тоосонцор	Жилд 2 удаа 3 цэгт	Тоосны агууламжийн хэмжилтийг Загийн усны хоолойн өргөлтийн 2-р насосын цэгт хийж гүйцэтгэсэн ба хэмжилтийн хариунаас харахад нарийн ширхэглэгт тоосонцор PM2.5 болон том ширхэглэгт тоосонцор PM10-н хэмжээ нь Монгол улсын агаарын чанарын MNS4585:2016 стандартаас давсан үзүүлэлтгүй байна.	100%
11.1.2	Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ	Жилд 1 удаа 1 цэгт	Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газраар Загийн усны хоолойн 3-н цэгээс агаарын чанарын сорьц цуглуулж шинжлүүлсэн.	100%
11.1.3	Дуу чимээний хяналт	Жилд 2 удаа 2 цэгт	Загийн усны хоолойн төслийн гүний худгууд болон ус өргөх насосын нийт 5-н цэгээс дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Шинжилгээний хариу Монгол улсын агаарын чанарын MNS4585:2016 стандартаас давсан үзүүлэлтгүй байна.	100%

11.1.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ


Цаг уур, орчны шинжилгээний газрын Архив, мэдээллийн сангийн хэлтсээс Тавантолгой цаг уурын станцын агаарын температур, салхины хурд, хур тунадас, агаарын даралтын мэдээллийг худалдан авч тоосны тархалтад хэрхэн нөлөөлж байгааг судлахыг зорилго болгон ажилласан.

Хүснэгт № 8. Цаг агаарын үзүүлэлт

Он сар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Агаарын температур /градус °C/												
2023	-13.5	-6.9	0.7	5.6	13.5	22.7		23.6	16.6			
Хур тунадас /мм/												
2023	3.80	2.00	0.00	0.00	3.40	8.30		11.60	6.80			
Салхины хурд /м/с/												
2023	4.5	3.4	4.3	6.4	4.5	4.9		11.3	12.0			

Тоосны агууламжийн хэмжилтийг АНУ-н TSI үйлдвэрийн Dusttrak 8530 төхөөрөмж ашиглан хийж гүйцэтгэсэн. Төслийн ус татах шугам хоолой угсралтын газар шорооны ажил дуусаж нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн ба зөвхөн худгийн барилгын ажил хийгдэж байсантай холбоотой агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага байна. Хэмжилтийг Монгол улсын стандарт MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Салбарын захирлын батласан “ЭТТ-СА-Ж06-БО-Ж02-Х02 Байгаль орчны хяналт шинжилгээний журам”, “ЭТТ-СА-3А101-БО-Х01 Агаарын чанарын хяналт явуулах заавар”-г тус тус баримтлан хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.

Хэмжилтийн дүнгээс харахад нарийн ширхэглэгт тоосонцор PM 2.5-н хэмжээ 21мкг/м³ хэмжээтэй буюу стандартын зөвшөөрөгдөх хэмжээнд байна.



Диаграмм № 1. Тоосны хэмжилтийн дата мэдээ

11.1.2 Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээ

Өмнөговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын шинжээч төслийн талбайн өргөх насос станц 1, 2 болон усан сан гэсэн цэгүүдээс агаарын сорьц цуглуулан хийн төлөвт агаар бохирдуулагч болох хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, PM_{2.5} тоосонцор гэсэн үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.

Шинжилгээний дүн стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Хүснэгт № 9. Хийн төлөвт агаар бохирдуулагчийн шинжилгээний үр дүн

№	Байршил	SO ₂	NO ₂	PM _{2.5} тоосонцор /20 минутаар	PM ₁₀ тоос /20 минутаар
		мкг/м ³			
1	2x1500м ³ усан сан	21	47	78	179
2	Өргөлтийн насос станц-2	13	17	63	84
3	Өргөлтийн насос станц-1	15	16	40	67

11.1.3 Дуу чимээний хяналт

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээний хэмжээ нь нөлөөллийн бүсийн айл өрх, ан амьтан, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянах зорилгоор гадаад орчны дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийг PCE-EM882 Multi-Function environment meter буюу орчны хэмжилтийн багажаар хэмжсэн. Хэмжилтийн дүн MNS 4585:2016 Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлагат тусгасан дуу чимээний хэмжилтийн өдрийн цагийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 60дБа-с бага байна.



Зураг № 41. Дуу чимээний хэмжилт хийж буй байдал

Хүснэгт № 10. Дуу чимээний хэмжилтийн дата мэдээ

№	Хэмжилтийн цэг	Хэмжилтийн үтгэ	ЗДХ
1	Өргөлтийн насос №2	58.9 dBa	60 dB
		60.3 dBa	60 dB
		57.2 dBa	60 dB
2	Загийн усны хоолой худаг №13	31.2 dBa	60 dB
		32.8 dBa	60 dB
		31.9 dBa	60 dB
3	Өргөлтийн насос №1	23.5 dBa	60 dB
		31.3 dBa	60 dB
		32.8 dBa	60 dB
4	Загийн усны хоолой худаг №12	30.0 dBa	60 dB
		43.0 dBa	60 dB
		35.9 dBa	60 dB
5	Загийн усны хоолой худаг №1	20.4 dBa	60 dB
		14.7 dBa	60 dB
		16.9 dBa	60 dB

11.2 Усан орчны хяналт шинжилгээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.2.1	Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ	14 худагт 2 удаа	Гүний усны худгуудыг өрөмдөж тоноглох үед гүний усны худгуудаас дээж авч шинжлүүлсэн. Гүний усны худгуудад насос суурилуулаагүй байгаа тул дахин усны дээж авах боломжгүй байна.	50%
11.2.2	Худгуудын бактериологийн усны шинжилгээ	14 худагт 2 удаа	Гүний усны худгуудыг өрөмдөж тоноглох үед гүний усны худгуудаас дээж авч шинжлүүлсэн. Гүний усны худгуудад насос суурилуулаагүй байгаа тул дахин усны дээж авах боломжгүй байна.	50%

11.2.1 Усны хими, физикийн ерөнхий шинжилгээ

Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн үйл ажиллагаанаас нөлөөллийн бүсийн малчны худгуудад үзүүлэх сөрөг нөлөөг хянах зорилгоор малчны худгуудаар явж бага гүний уст худгуудын усны түвшин хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн үед худаг ашиглагч малчдыг байлцуулж хэмжилтийг хамтран гүйцэтгэж ажилласан.

Хүснэгт № 11. Хэмжилт хийсэн малчны худгийн мэдээлэл

Худаг №	Хэмжилт хийсэн огноо	Хэмжилт хийсэн цаг, минут	Салхины хурд м/с	Усны түвшин, м
Үнэгд	2023.08.17	11:35	2.3	2.6
Хангийн ус	2023.08.17	12:17	0.28	2.38
Овдой	2023.08.17	13:00	1.4	2.1
Дэрсэн ус	2023.08.17	13:20	0.48	2.26
Ботууль	2023.08.17	13:43	1.72	6.1
9-р худгийн хажууд цооног/Батхуяг/	2023.08.17	14:58	3.2	19.23
Хацавч	2023.08.17	15:54	0.36	2.75



Зураг № 42. Малчны худгийн хэмжилт хийж буй байдал

11.2.2 Усны чанарын шинжилгээ

Гүний усны худгуудыг өрөмдөж тоноглох үед гүний усны худгуудаас дээж авч шинжлүүлсэн. Гүний усны худгуудад насос суурилуулаагүй байгаа тул дахин усны дээж авах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Хүснэгт № 12. Усны чанарын шинжилгээний хариу

Он сар	Худаг	рН	Кальци	Карбонат	Магний	Натрий+Кали	Нитрат	Нитрит	Сульфат	Аммоний	Хлорид	Гидрокарбонат	Ерөнхий хатуулаг	Төмөр	Цахилгаан дамжуулах чанар	Хуурай үлдэгдэл
			/мг/л/											мг-экв / л	мСм/см	мг/л

2022.10.27	Худаг №1	7.41	60.12	0.05	46.21	2089.00	3.87	0.00	344.38	0.22	751.54	210.00	6.80	0.02	3.03	2089.00
	Худаг №2	7.49	60.12	0.10	60.80	649.77	0.02	0.00	354.35	0.06	907.52	195.00	8.00	4.26	3.24	2116.00
	Худаг №3	7.77	60.12	0.10	55.94	592.02	3.32	0.00	368.95	0.18	794.08	195.00	7.60	0.03	3.08	2048.00
	Худаг №4	7.36	68.14	0.10	60.80	689.01	4.55	0.00	364.01	0.12	978.42	189.00	8.40	0.02	3.45	2291.00
	Худаг №5	7.69	52.10	0	0.20	468.98	3.43	0.01	448.08	0.28	489.11	171.00	5.60	0.05	2.49	1151.00
	Худаг №6	7.75	34.07	0.20	20.67	328.53	1.82	0.00	228.21	0.13	311.96	250.00	3.40	0.04	1.72	1304.00
	Худаг №7	7.55	20.04	0.20	21.89	337.96	2.37	0.01	209.07	0.22	311.96	262.00	2.80	0.03	1.47	1224.00
	Худаг №8	8.33	36.91	0.7	31.96	406.06	17.08	0.00	393	0.18	336	250	4.47	-	1.93	1260
	Худаг №9	8.32	35.71	0.7	33.68	582.49	25.86	0.00	380	0.05	556	250	4.55	-	1.92	1596
	Худаг №10	7.87	30.47	0.7	26.67	438.17	26.89	0.00	349	0.05	395	244	3.72	-	2.06	1390
	Худаг №11	7.67	55.08	0.7	49.44	612.88	23.34	0.00	245	0.05	884	195	6.82	-	2.74	1888
	Худаг №12	7.74	38.72	0.7	33.59	385.37	22.17	0.00	406	0.05	348	238	4.70	-	1.84	1298
	Худаг №13	7.64	88.18	0.10	77.82	1291.27	4.56	0.00	675.30	0.27	1744.10	220.00	10.80	0.03	3.49	2216.00
	Худаг №14	7.68	52.10	0.10	41.34	722.23	5.38	0.01	471.09	0.25	843.71	226.00	6.00	0.03	3.40	2173.00

Шинжилгээний дүнг MNS ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын стандарттай харьцуулан дүгнэхэд Na⁺, K⁺ Cl⁻, Хуурай үлдэгдэл, цахилгаан дамжуулах чанар нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.5-2 дахин их үзүүлэлттэй байна. Ерөнхий хатуулаг, Mg²⁺ нь мөн стандартаас давсан үзүүлэлттэй харагдаж байна.

11.3 Хөрс, ургамлан бүрхэвчийн хяналт, шинжилгээ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.3.1	Хөрсний агрохимийн үзүүлэлт	Жилд 2 удаа 5 цэгээс	“Инженер Геодези” ХХК-тай байгуулсан хөрсний шинжилгээ хийх гэрээний дагуу Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн 5-н цэгээс хөрсний дээж авч хөрсний агрохими, ерөнхий хими физик, хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлсэн.	100%
11.3.2	Ерөнхий хими, физик	Жилд 2 удаа 5 цэгээс		100%

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
11.3.3	Хөрсөн дэхь хүнд метал	Жилд 1 удаа 3 цэгээс		100%

11.3.1 Хөрсний агрохимийн үзүүлэлт

“Инженер Геодези” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хөрсний мониторингийн 5-н цэгээс дээж авч хөрсний механик бүрэлдэхүүн болон химийн үзүүлэлтүүдийг шинжлүүлэв.



Зураг № 43. Хөрсний дээж авч буй байдал

Хүснэгт № 13. Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Дээжний нэр	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	Загийн усны хоолой өргөлтийн насос №1	19.4	62.5	7.2	2.4	4.3	4.1	10.8
2	Загийн усны хоолой өргөлтийн насос №2	17.2	63.1	9.7	1.4	6.0	2.7	10.1
3	Загийн усны хоолой худаг №1	18.0	60.6	8.4	2.1	8.1	2.8	13.0
4	Загийн усны хоолой худаг №12	12.1	67.7	7.3	1.9	7.1	3.8	12.9
5	Загийн усны хоолой худаг №13	22.8	36.8	19.4	4.7	9.2	7.1	21.0

11.3.2 Хөрсний хими, физикийн шинжилгээ

Хүснэгт № 14. Хөрсний хими, физикийн үзүүлэлт

№	Дээжний нэр	pH	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	NO ₃ , мг/100г	CaCO ₃ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
								Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	Загийн усны хоолой өргөлтийн насос №1	8.76	0.09	0.188	0.46	0.17	0.49	8.3	2.0	2.6	20
2	Загийн усны хоолой өргөлтийн насос №2	8.85	0.09	0.205	0.33	0.11	0.49	8.2	5.0	2.1	37

3	Загийн усны хоолой худаг №1	8.80	0.13	0.271	0.52	0.13	0.99	9.6	1.6	1.7	35
4	Загийн усны хоолой худаг №12	9.02	0.12	0.242	0.36	0.15	0.82	9.6	3.6	2.2	31
5	Загийн усны хоолой худаг №13	8.84	0.32	0.708	0.28	0.13	3.62	14.6	4.4	2.0	68

11.3.3 Хөрсний хүнд металл шинжилгээ

Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг хянах зорилготой хяналтын 5-н цэгийг сонгож авч хөрсний хүнд металлын үзүүлэлтүүдийг шинжлүүлэхэд MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулах бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартын хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна.


Хүснэгт № 15. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн

№	Дээжний нэр	Хүнд металл					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /хар тугалга/	Cu /Зэс/	Zn /цайр/	Cr /хром/
1	Загийн усны хоолой өргөлтийн насос №1	22.3	-	22.2	17.4	36.4	-
2	Загийн усны хоолой өргөлтийн насос №2	17.6	-	16.3	14.6	51.6	-
3	Загийн усны хоолой худаг №1	15.6	-	15.8	12.7	28.9	10.7
4	Загийн усны хоолой худаг №12	17.5	-	15.7	14.1	60.3	8.91
5	Загийн усны хоолой худаг №13	26.6	-	28.7	24.6	55.2	-
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0

11.4 Ургамлын мониторинг

“Эрдэнэс таван толгой” ХК-ийн Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлж буй талбайн 3-с доошгүй байршилд ургамлын мониторингийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Тус төлөвлөгөөний дагуу 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Загийн усны хоолойгоос ус татах шугам хоолойн төслийн худгууд болон өргөлтийн насосын ойр орчмоос нийт 5-н цэгт ургамлын мониторингийн ажил хийж гүйцэтгэсэн.



Зураг № 44. Ургамлын мониторинг хийх байршлын зураг

Нөлөөллийн бүс орчмоор бэсрэг нам уулсууд Цэций уул (1790.2 м), Их Шанхай (1763.4 м)-н нуруу зэрэг уулсууд оршдог. Ургамалжлын хувьд дээрх бэсрэг, нам уулсын энгэр бэлээр монгол өвс-таана (*Allium polyrhizum-Stipa gobica*)-т цөлийн хээр, цав толгодын хоорондох өргөн хөндий, тэгш талаар баглуур-монгол өвс (*Stipa gobica-Anabasis brevifolia*)-т цөлийн хээр түгээмэл тааралдах ба нам хөндий рүү бударгана-монгол өвс (*Stipa gobica-Reaumuria soongorica*)-т цөлийн хээр, тэгш тал газраар хэсэг хэсэг бор бударгана (*Salsola passerina*)-т цөлжүү хээр, хөндийн ёроол, сайр дагуу ба хонхор хотсын захаар дэрс (*Achnatherum splendens*)-т бүлгэмдэл элбэг.

Нам дор газрын хаяа, тэдгээрийн ихээхэн шорвогжсон хөрстэй марзлаг хотгоруудаар улаан бударгана (*Reaumuria soongorica*)-т цөлийн бүлгэмдэл, илүү их марзлаг юмуу шорвогжсон өнгөндөө давс хужир харваж гарсан нөхцөлд давс хужирсаг улаанбударган (*Reaumuria soongorica*)-аас гадна шарбударгана (*Kalidium gracile*), дэрс (*Achnatherum splendens*) зэрэг давссаг ургамал элбэг. Улаан нуурын тойрмын ургамалжил өвөрмөц төрхтэй. Тойрмын захын товцог элсэн дээгүүр хармаг (*Nitraria sibirica*) арви өндөр ургадаг.

Хүснэгт № 16. Ургамлын мониторингийн бичиглэл

Ургамлын мониторингийн цэг: 1



Талбайн төлөв, байдал

Ургамлын бүлгэмдлийн нэр	Хазаар өвс
Газрын гадаргуугийн хэлбэр	Тал
Ургамлын бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц	30%
Ургамал бүлгэмдлийн дундаж өндөр	6-11см
Хөгжлийн үе шат	хагдарсан
Зонхилох ургамал: Монгол өвс Халцгай газрын эзлэх хувь: 70%	
Ургамлын мониторингийн цэг: 2	



Талбайн төлөв, байдал

Ургамлын бүлгэмдлийн нэр	Говийн Хялгана- <i>Stipa gobica</i> бор бударгана
Газрын гадаргуугын хэлбэр	Тал газар
Ургамлын бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц	11%
Ургамал бүлгэмдлийн дундаж өндөр	5 см
Бүлгэмдлийн нийт зүйлийн тоо	2
Хөгжлийн үе шат	хагдарсан
Зонхилох ургамал: Хялгана, бор бударгана Халцгай газрын эзлэх хувь: 89	
Ургамлын мониторингийн цэг: 3	



Талбайн төлөв, байдал

Ургамлын бүлгэмдлийн нэр	Говийн Хялгана- <i>Stipa gobica</i> цөлийн хиаг, боролз
Газрын гадаргуугын хэлбэр	Тал газар
Ургамлын бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц	74%
Ургамал бүлгэмдлийн дундаж өндөр	2-4см
Бүлгэмдлийн нийт зүйлийн тоо	2
Хөгжлийн үе шат	хагдарсан
Зонхилох ургамал: Хялгана, цөлийн хиаг, боролз Халцгай газрын эзлэх хувь: 26%	
Ургамлын мониторингийн цэг: 4	



Талбайн төлөв, байдал

Ургамлын бүлгэмдлийн нэр	Говийн Хялгана- <i>Stipa gobica</i> улаан бударгана, бор бударгана- <i>Salsola passerina</i>
Газрын гадаргуугын хэлбэр	Тал газар
Ургамлын бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц	17%
Ургамал бүлгэмдлийн дундаж өндөр	7см
Бүлгэмдлийн нийт зүйлийн тоо	3
Хөгжлийн үе шат	хагдарсан
Зонхилох ургамал: Зүүнгарын улаан бутаргана- <i>Reaumuria soongorica</i> Халцгай газрын эзлэх хувь: 83%	

Ургамлын мониторингийн цэг: 5



Талбайн төлөв, байдал

Ургамлын бүлгэмдлийн нэр	Цөлийн хиаг, Говийн Хялгана- <i>Stipa gobica</i>
Газрын гадаргуугын хэлбэр	Тал газар
Ургамлын бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц	21%
Ургамал бүлгэмдлийн дундаж өндөр	5-6см
Бүлгэмдлийн нийт зүйлийн тоо	2
Хөгжлийн үе шат	хагдарсан
Зонхилох ургамал: Цөлийн хиаг, хялгана Халцгай газрын эзлэх хувь: 79%	


11.5 Амьтны мониторинг судалгаа

Бид бүхэн “Загийн суны хоолой” төслийн талбайд 2023 оны 10-р сард “Эрдэнэс Тавантолгой” ХК-н мэргэжилтнүүдтэй хамтран амьтны мониторинг ажлыг гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд төслийн талбайн үйл ажиллагаа явуулж буй хэсэг болон нөлөөллийн бүс орчмын зонхилох том хөхтөн, махчтан, шувууны зүйлийн бүрдэлийн тодорхойлох зорилгоор тухайн ажлыг гүйцэтгэсэн болно.

Алтайн өвөр говь, Говь алтайн нуруу, Алашаа говь, Дорнод говь зэрэг нутгуудад тархан амьдардаг туруутан болон махчтан, жижиг хөхтөн амьтадын зан төрх, амьдрах идэвхийг үндэслэн цаг уурын нөхцөл байдлыг харгалзан үзэж сэрүүн үүлэрхэг өдрийг сонгон авч судалгааг гүйцэтгэсэн.

Төслийн нутаг амьтны аймгийн мужлалаар Хойд говийн тойрогт хамрагдах ба гадаргын байдал нь бэсрэг ба нам уулс, ухаа толгод, тал, цөлөрхөг хээр хосолсон нутаг юм. Иймд энд цөлөрхөг хээрийн хөрс, ургамал, амьтны бүрдлийг агуулсан экосистемийн

тогтолцоотой. Төслийн нутаг Монгол орны байгалийн бүс бүслүүрийн ангилалаар Заримдаг цөлийн бүсэд багтана.



Зураг № 45. Судалгааны талбайн байршлын зураг

Хээрийн хайгуул судалгааны талбайг сонгохдоо үйл ажиллагаа явуулж буй төслийн орчны бүс болон нөлөөллийн бүсийг хамруулан судалгааны ажлыг гүйцэтгэсэн. судалгаа хийгдэх талбайн гадаргын онцлог, хэмжээ, амьтны тархац зэргийг харгалзан үзэж 6 цэгт шулуун замналын аргаар 72 км талбайд судалгааны ажлыг гүйцэтгэсэн.

Сонгон авсан талбайд түгээмэл хэрэглэдэг, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, арга зүйн дагуу цэгэн, зурвас замнал, ул мөр болон аман асуулгын аргаар баданга хүдрийн судалгааны эх хэрэглэхүүнийг цуглуулав. Түүнчлэн судалгааны арга зүйг тухайн амьтныхаа зан төрх, экологи, биологийн онцлогтой уялдуулан сонгон авсан бөгөөд сорилын талбайд ажиглалт, судалгаа хийх цэг, замнал нь тухайн амьтны амьдрах орчныг бүрэн хамарсан байхад анхаарч байв.

Ажиглалтын явцад амьтан харвал боломжтой бол нас хүйсээр нь ангилж, ажиглалт хийсэн цаг, сар өдөр, амьдрах орчин, солбицол, зан авир, амьтан хүртэлх зай, өнцөг зэргийг тухайн арга зүйд тохирсон урьдчилан бэлтгэсэн хүснэгтэд тэмдэглэж байлаа.

Тухайн бүс нутгийн өмнөх судалгаанаас авч үзвэл 6 зүйл мөлхөгч, 53 зүйл шувуу, гар далавчтан 1, туулай хэлбэртэн 1, мэрэгчтэн 16, махчтан 4, туурайтэн 1, туруутан 3 зүйл нийт 7 багийн 33 зүйл хөхтөн тохиолдох боломжтой.

Энэ удаагийн судалгаагаар нийт 250 км замыг туулсан бөгөөд тухайн ажиглалтын талбайд 3 зүйл туруутан, 1 зүйл махчин шувуу бүртгэгдсэн болно. Үүнд цагаан зээр/ *Procapra gutturosa* / 23, хар сүүлт зээр / *Gazella subgutturosa* / 6 шаргачин 1 янзага, тас 3 нийт 3 зүйл 35 бодгаль бүртгэгдэв.



Зураг № 46. Цагаан зээр-*Procapra gutturosa*



Зураг № 47. Хар сүүлт зээр-*Gazella subgutturosa*

Монгол орны өмнө, дорнын уудам тал, ухаа толгодоор идээшиж бэлчдэг. Туурайтны баг болох тугалмайтны овогт багтах бөгөөд эрэгчинг ооно, эмэгчинг шаргачин, төлийг янзага, эрэгчин шүдлэнг цэнхэр ооно, охни шүдлэнг зусаг шаргачин гэнэ. Голдуу хул шар зүстэй, богино сүүлтэй, тангийнхаа захаар шар хүрээтэй, шаргачин зургаадугаар сард янзаглана.

Говь цөлд шүтэн амьдардаг зүйл туруутан амьтан болох Харсүүлт зээрийн хамгаалал нь “Загийн усны хоолой” төсөлтэй зайлшгүй хамааралтай юм. Хар сүүлт зээр Төв Азийн цөл гандуу бүс нутгийн нөхцөлд маш сайн зонхилдсон туруутан амьтан. (Clauss et al., 2002)

Бидний судалгаа хийсэн хугацаа богино, мөн тогтоол ус, задгай булагуудад амарч хүчээ сэлбэн дайран өнгөрдөг нүүдлийн шувууд буцсан үе байлаа. “Загын усны хоолой” төслийн орчимд тэмдэглэгдсэн шувуудын олонхи нь суурин өвөлждөг зүйлүүд байсан. Хамгийн элбэг тохиолдох шувууд нь хадны бор шувуу, шороон эвэрт болжмор, хээрийн бор шувуу, хар хэрээ юм. Амьтнаар хооллодог шувуу хамгийн олон байгаа нь энд тэдгээрийн идэш болдог амьтны тоо толгой элбэг болохыг харуулж байна.



Зураг № 48. Нөмрөг тас /*Aegyrus monachus*/

Тухайн төслийн үр дүнгээс харвал нүүдлийн шувууд дамжин өнгөрөх ил задгай уст цэгүүд бий болж байгаа нь дан ганц шувуу гэлтгүй бүх зүйлийн амьтад ундаалах таатай нөхцөл үүсч байгаа юм.

Дүгнэлт: Загын усны хоолойн орчны бүсэд амьтан ажиглах, бүртгэх мониторингийг 6 цэгт болон шулуун замналын аргаар хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Эдгээр цэгийг сонгохдоо амьтдын амьдрах орчны ялгаатай байдал аараг толгод, дэрстэй хоолой, уст цэг зэрэг өөр өөр орчныг хамруулахаас гадна байршлын хувьд харууц сайтай, тухайн орчноосоо өндөрлөг байхаар тооцсон.

Энэ удаагийн судалгаагаар нийт 250 км замыг туулсан бөгөөд тухайн ажиглалтын талбайд 3 зүйл туруутан, 1 зүйл махчин шувуу бүртгэгдсэн болно. Үүнд цагаан зээр/ *Procapra gutturosa* / 23, хар сүүлт зээр / *Gazella subgutturosa* / 6 шаргачин 1 янзага, тас 3 нийтлэг тохиолдох хадны бор шувуу, шороон эвэрт болжмор, хээрийн бор шувуу, хар хэрээ нийт 3 зүйл 35 бодгаль бүртгэгдэв.

Цаашид тус судалгааны ажлыг улирал тутамд өргөн хүрээний газар нутгийг хамруулсанаар зүйлийн бүрдэл, тархац, байршил тоо толгойн талаар илүү бодитой үр дүн мэдээ баримт цуглуулж түүнд тулгуурлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд илүү хялбар болж өгөх юм.

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
12.1	Байгаль орчны аудит хийлгэх.	Төслийн хэмжээгээр	Тендер шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн бичиг баримтыг боловсруулан тендерийг 2023 оны 07-р сарын 06-ны өдөр анх зарласан бөгөөд хураангуй жагсаалт үүсээгүй шалтгаанаар амжилтгүй болсон. Тендерийг 09-р сарын 01-ны өдөр дахин зарлаж 9-р сарын 25-ны өдөр нээсэн бөгөөд 6 компани оролцож хураангуй жагсаалт үүсэн тул хураангуй жагсаалтанд орсон компаниудад үнийн санал илгээх урилгыг 09-р сарын 26-ны өдөр илгээж 10-р сарын 02-ны өдөр нээж тендерийг үнэлээд “Эковишн” ХХК шалгарч гэрээ байгуулах шатандаа байна. Тайлант онд багтааж уг ажлыг гүйцэтгүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	50%
12.2	БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах	-	БОМТ-ийн барьцаа хөрөнгийг БОАЖЯ-ны дансанд 100 хувь байршуулсан.	100%
12.3	Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах	-	Загийн усны хоолойн ус хангамжийн төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/-г БОАЖЯ-аар батлуулсан.	100%
12.4	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг ажлын хэсгээр дүгнүүлэх	1 удаа	БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулан журмын дагуу хянуулахаар Өмнөговь аймгийн БОАЖГ-г хүргүүлсэн.	100%

12.1 Байгаль орчны хөндлөнгийн аудит хийлгэх

Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх захилагын худусыг Байгаль орчин, усны бодлогын хэлтсээс 2023 оны 02-р сарын 12-ны өдөр боловсруулан батлуулан төв оффисийн Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн газарт хүргүүлсэн.



Зураг № 49. Захиалгын хуудсыг боловсруулан батлуулж хүргүүлсэн байдал

Уг захиалгын хуудсын дагуу тендер шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн бичиг баримтыг боловсруулан тендерийг 2023 оны 07-р сарын 06-ны өдөр анх зарласан бөгөөд хураангуй жагсаалт үүсээгүй шалтгаанаар амжилтгүй болсон. Тендерийг 09-р сарын 01-ны өдөр дахин зарлаж 9-р сарын 25-ны өдөр нээсэн бөгөөд 6 компани оролцож хураангуй жагсаалт үүсэн тул хураангуй жагсаалтанд орсон компаниудад үнийн санал илгээх урилгыг 09-р сарын 26-ны өдөр илгээж 10-р сарын 02-ны өдөр нээж тендерийг үнэлээд “Эковишн” ХХК шалгарч гэрээ байгуулах шатандаа байна. Тайлант онд багтааж уг ажлыг гүйцэтгүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

12.2 БОМТ-ний барьцаа хөрөнгө байршуулах

Тухайн жилийн байрагль орчны менежментийн төлөвлөгөөний барьцаа хөрөнгийг БОАЖЯ-наас асууж тодруулсаны эцэст Цогтцэций сумын Төрийн санд шилжүүлсэн боловч БОАЖЯ-ны дансанд шилээүүлэх шарадлагатай гэсэн тул уг хөрөнгийг 100 хувь шилжүүлсэн.

12.3 Жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны сайдын баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, тайлагнах” журмын дагуу боловсруулан Өмнөговь аймгийн БОАЖГ-аар хянуулан, БОАЖЯ-аар батлуулсан.



Зураг № 50. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан байдал

13. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Тоо хэмжээ Х.Н	Хэрэгжилт	Биелэлт %
13.1	Багийн иргэд, нийтийн хурал	Танхимаар 1 удаа	Төсөл хэрэгжиж буй бүс нутаг болох Цогтцэций сумын Билгэх, Сийрст багуудын Иргэдийн нийтийн хуралд төслийн үйл ажиллагааны талаар болон БОМТ-ний хэрэгжилтийн талаар мэдээ мэдээлэл өгч иргэдийн санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.	100%
13.2	Нөлөөллийн бүсийн иргэд, сумын удирдлага, мэргэжилтэн	Жилд 2 удаа	Цогтцэций сумын удирдлагууд, ИТХ-ийн төлөөлөгчид, сумын иргэдэд төслийн үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулга өгч ажилласан. Мөн нөлөөллийн бүсийн айл өрхүүдээр нэг бүрчлэн орж уулзан тэдний санал хүсэлтийг сонсч төслийн үйл ажиллагааны талаар тухай бүрт мэдээлэл өгч ажилласан.	100%

13.1 БОМТ танилцуулах хурал

